9	ШТС-аас цэнэглэсэн баримтгүй, жолооч замын хуудсыг тодорхой бус хөтөлсөн, захирамж, тушаалын дагуу зарцуулаагүй, эрх бүхий албан тушаалтан хянаж баталгаажуулаагүй баримтаар шатахууны зарлага гаргаж тайлагнасан.	1	52,770.0	-	-	-	-	1	52,770.0	-	-	-	-
10	Батлагдсан төсвийн эдийн засгийн ангилал зөрчиж шуудан холбооны зардлаас 4,560.0 мянган төгрөгийг ашиглалтын зардал, түрээсийн төлбөр төлсөн байна.	1	4,560.0	-	-	-	-	1	4,560.0	-	-	-	-
11	Гэрээ байгуулаагүй, хийж гүйцэтгэсэн ажлын тайлангүй, нотлох баримтгүй урсгал засварын зардал гаргасан.	1	51,581.9	1	51,581.9								
12	Ажилтныг томилолтоор ажилласан хугацаанд нь 4,124.0 мянган төгрөгийн хоол, унааны мөнгө давхардуулан олгосон байна.	1	4,124.0	1	4,124.0								

Нийслэлийн Баянзүрх дүүргийн Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

13	Оны эцэст албан хаагчид ээлжийн амралтын нөхөн олговорт 6,421.5 мянган төгрөгийн цалин олгож төсвийн хөрөнгийг үрэлгэн зарцуулсан.	1	6,421.5	1	6,421.5								
14	Тушаал шийдвэргүй, ажлын байрны тодорхойлолт заасан чиг үүргээ хэрэгжүүлсэн албан хаагчдад илүү цагийн хөлс олгосон байна.	1	18,467.3	1	18,467.3								
	Дүн	14	1,164,621.2	4	80,594.7	-	-	8	1,084,026.5	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

д/д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжүүлээгүй. БЗД-ийн нутаг дэвсгэр дэх газрын зөрчил арилгаж газар чөлөөлөх зардалд 3.9 тэрбум төгрөг зарцуулсан байна. Ингэхдээ НИТХ-аас оны эхэнд газрын зөрчилтэй, чөлөөлөх газрын жагсаалт батлагдаж байгаа нь энэхүү зардал төлөвлөгдөж ХАА зохион байгуулж болохуйц нөхцөлтэй байхад ямар нэгэн сонгон шалгаруулалт хийгээгүй, зардлын жишиг норм тогтоогоогүй, босго үнийн хязгаарт багтаан хувааж гэрээ хийсэн, батлагдсан хуваарьт ороогүй газруудыг чөлөөлөх ажил зохион байгуулагдаж байна.	1	3,936,176.3	-	-	1	3,936,176.3	-	-
2	Нэг ижил төрлийн бараа, ажил үйлчилгээний худалдан авалт хийхдээ, тендер шалгаруулалтын журмыг зөрчин төсөвт өртгийг хувааж гэрээг шууд байгуулж, бараа, ажил үйлчилгээ худалдан авсан, үр дүнг үнэлж, гэрээ дүгнэсэн акт үйлдээгүй, ажлын гүйцэтгэл, тайлан зэрэг нотлох баримт хангалтгүй.	1	1,904,373.6	-	-	1	1,904,373.6	-	-
3	Үйл ажиллагааны чиглэл өөр байгууллагуудаас 101,636.0 мянган төгрөгийн засвар, ажил үйлчилгээ, зохион байгуулсан байна.	1	101,636.0	-	-	1	101,636.0	-	-

Нийслэлийн Баянзүрх дүүргийн Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

4	Туршлага судлах, сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулахаар шийдвэр гаргаж ресторан, аяллын компаниудтай гэрээ байгуулан 628,817.0 мянган төгрөгийн зардал гаргаж, төсвийг үрэлгэн зарцуулсан, ямар хөтөлбөр удирдамжаар хэн явах нь тодорхой бус шийдвэртэй, ажил гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулсан боловч үр дүнг үнэлж, гэрээ дүгнэсэн акт үйлдээгүй зэрэг нотлох баримт хангалтгүй байна.	1	628,817.0	-	-	1	628,817.0		
5	Хугацаа хэтэрсэн 406,279.8 мянган төгрөгийн авлагын үлдэгдэлтэй, уг авлагуудыг барагдуулах арга хэмжээ авч ажиллаагүй байна. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжүүлээгүй байна.	1	406,279.8	-	-	1	406,279.8		
6	Шилэн дансны цахим хуудсанд таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 41,339,228.7 мянган төгрөгийн орлогын 149 гүйлгээг хугацаанд нь мэдээлээгүй, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 36, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 155, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 103 шийдвэрийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.	1	-	-	-	1	-		
	Дүн	6	6,977,282.7	-	-	6	6,977,282.7	-	-



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 02 дугаар сарын 25

№ 57 / АУ260171

Улаанбаатар хот

НТАГ-2026/179/НА-СТА-ТШЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянзүрх дүүргийн Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Гэрээ байгуулаагүй, хийж гүйцэтгэсэн ажлын тайлангүй, нотлох баримтгүй нийт 51,581,900.00 (тавин нэгэн сая таван зуун наян нэгэн мянга есөн зуу) төгрөгийн урсгал засварын зардал гаргасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйл 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.8-д "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" заалтад заасныг үндэслэн ТОГТООХ нь:

1. Нотлох баримтгүй зарцуулсан 51,581,900.00 (тавин нэгэн сая таван зуун наян нэгэн мянга есөн зуун) төгрөгийг Баянзүрх дүүргийн Засаг даргын тамгын газрын дарга Д.Бат-Өлзий, ерөнхий нягтлан бодогч Б.Алтаншагай нараар төлүүлж Нийслэл дэх Төрийн аудитын газрын төрийн сан дахь НТАГ хүү торгуулийн орлогын MN440090100200000908 тоот дансанд төвлөрүүлэх;

2. Актын биелэлтийг 2026 оны 05 дугаар сарын 30-ны дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэхийг Баянзүрх дүүргийн Засаг даргын тамгын газрын дарга Д.Бат-Өлзий, ерөнхий нягтлан бодогч Б.Алтаншагай нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР

Г.НАНДИНЖАРГАЛ
Я.АЛТАНЦЭЦЭГ
Н.БАТТОГОО

¹ Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, А.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар

1426110188



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 02 дугаар сарын 25

№ 58/А0260191

Улаанбаатар хот

НТАГ-2026/179/НА-САА-ТШЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянзүрх дүүргийн Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тушаал шийдвэргүй, ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлсэн албан хаагчдад 18,467,300.00 (арван найман сая дөрвөн зуун жаран долоон мянга гурван зуун) илүү цагийн хөлс хавтгайруулан олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйл 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно", 15.1.3-д "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгаагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.3-д "цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон" заалтад заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Илүү цагийн хөлс хавтгайруулан олгосон 18,467,300.00 (арван найман сая дөрвөн зуун жаран долоон мянга гурван зуун) төгрөгийг Баянзүрх дүүргийн Засаг даргын тамгын газрын дарга Д.Бат-Өлзий, ерөнхий нягтлан бодогч Б.Алтаншагай нараар төлүүлж Нийслэл дэх Төрийн аудитын газрын төрийн сан дахь НТАГ. хүү торгуулийн орлогын МН440090100200000908 тоот дансанд төвлөрүүлэх;

2. Актын биелэлтийг 2026 оны 05 дугаар сарын 30-ны дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэхийг Баянзүрх дүүргийн Засаг даргын тамгын газрын дарга Д.Бат-Өлзий, ерөнхий нягтлан бодогч Б.Алтаншагай нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР

Г.НАНДИНЖАРГАЛ
Я.АЛТАНЦЭЦЭГ
Н.БАТТООГО

¹ Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, А.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар

1426110191



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 02 дугаар сарын 25

№ 59/А0260179

Улаанбаатар хот

МНА/-2026/179/НА-СТА-ТШЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянзүрх дүүргийн Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Ажилтныг томилолтоор ажилласан хугацаанд нь 4,124,000.00 (дөрвөн сая нэг зуун хорин дөрвөн мянган) төгрөгийн хоол, унааны мөнгө илүү олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйл 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3-д "Албан томилолтоор ажиллаж байгаа албан хаагчийн тээврийн хэрэгсэл, байр, хоолны зардлыг албан томилолтоор ажиллуулсан байгууллага төсөвлөж олгосон тохиолдолд энэ хуулийн 3.1-д заасан байгууллага, албан тушаалтнаар төлүүлэхийг хориглоно" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгаагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.3-д "цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон" заалтад заасныг үндэслэн **ТОГТООХ** нь:3

1. Илүү олгосон унаа, хоолны 4,124,000.00 (дөрвөн сая нэг зуун хорин дөрвөн мянган) төгрөгийг Баянзүрх дүүргийн Засаг даргын тамгын газрын дарга Д.Бат-Өлзий, ерөнхий нягтлан бодогч Б.Алтаншагай нараар төлүүлж, Нийслэл дэх Төрийн аудитын газрын төрийн сан дахь НТАГ. хүү торгуулийн орлогын MN440090100200000908 тоот дансанд төвлөрүүлэх;

2. Актын биелэлтийг 2026 оны 05 дугаар сарын 30-ны дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэхийг Баянзүрх дүүргийн Засаг даргын тамгын газрын дарга Д.Бат-Өлзий, ерөнхий нягтлан бодогч Б.Алтаншагай нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР

Я.АЛТАНЦЭЦЭГ
Н.БАТТОГОО

¹ Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, А.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар

1426110189

Нийслэлийн Баянзүрх дүүргийн Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 02 дугаар сарын 25

№ 60/А0260171

Улаанбаатар хот

НААГ-2026/179/НА-СТА-ТШЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянзүрх дүүргийн Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Оны эцэст албан хаагчид ээлжийн амралтын нөхөн олговорт 6,421,500.00 (зургаан сая дөрвөн зуун хорин нэгэн мянга таван зуун) төгрөгийн цалин олгож, төсвийн хөрөнгийг үрэлгэн зарцуулсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйл 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно", 15.1.3-д "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагналыг урамшуулал, дэмжлэг олгох" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгаагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.3-д "цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон" заалтад заасныг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Төсвийн хөрөнгийг үрэлгэн зарцуулсан 6,421,500.00 (зургаан сая дөрвөн зуун хорин нэгэн мянга таван зуун) төгрөгийг Баянзүрх дүүргийн Засаг даргын тамгын газрын дарга Д.Бат-Өлзий, ерөнхий нягтлан бодогч Б.Алтаншагай нараар төлүүлж Нийслэл дэх Төрийн аудитын газрын төрийн сан дахь НААГ. хүү торгуулийн орлогын МН440090100200000908 тоот дансанд төвлөрүүлэх;

2. Актын биелэлтийг 2026 оны 05 дугаар сарын 30-ны дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэхийг Баянзүрх дүүргийн Засаг даргын тамгын газрын дарга Д.Бат-Өлзий, ерөнхий нягтлан бодогч Б.Алтаншагай нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР

Е.НАНДИНЖАРГАЛ
Я.АЛТАНЦЭЦЭГ
Н.БАТТОГОО

¹ Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, А.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар

1426110193



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 221 /АУГБ0171

Улаанбаатар хот

НТАГ-2026/179/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянзүрх дүүргийн Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжүүлж ажиллаагүй. Дүүргийн нутаг дэвсгэр дэх газрын зөрчил арилгаж, газар чөлөөлөх зардалд 3,936,176,300.00 (гурван тэрбум өсөн зуун гучин зургаан сая нэг зуун далан зургаан мянга гурван зуун) төгрөгийг зарцуулсан байна.

Ингэхдээ Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлаас оны эхэнд газрын зөрчилтэй, чөлөөлөх газрын жагсаалт батлагдаж байгаа нь энэхүү зардал төлөвлөгдөж худалдан авах ажиллагааг зохион байгуулж болохуйц нөхцөлтэй байхад ямар нэгэн сонгон шалгаруулалт хийгээгүй, зардлын жишиг норм тогтоогоогүй, босго үнийн хязгаарт багтаан хувааж гэрээ хийсэн, батлагдсан хуваарьт ороогүй газруудыг чөлөөлөх ажил зохион байгуулагдаж байна.

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3-д "Шалгаагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн хүрээнд хэрэгжүүлсэн ажил, түүний үр дүнг төрийн аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд мэдэгдэнэ", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5-д "Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.7-д "аливаа үйл ажиллагааны зохион байгуулалт нь өртөг зардлын бодит тооцоолол, баталсан стандарт, хэрэгцээ, шаардлагад үндэслэгдсэн байх" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.9-д "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол", 4.2.1.10-д "аудитаар илэрсэн алдаа,

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, А.Амарын гудамж, Соёлын төв өргөө,
Г корпус, 5 давхар

1426090509

Нийслэлийн Баянзүрх дүүргийн Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” заалтад заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1.Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжүүлж ажиллаагүй, шууд гэрээ байгуулж, ажил үйлчилгээ хийлгэсэн зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 09 дүгээр сарын 30-ны дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэх;

2.Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баянзүрх дүүргийн Засаг даргын тамгын газрын дарга Д.Бат-Өлзий, ерөнхий нягтлан бодогч Б.Алтаншагай нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР



Г.НАНДИНЖАРГАЛ
Я.АЛТАНЦЭЦЭГ
Н.БАТТОГОО

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, А.Амарын гудамж, Соёлын төв өргөө,
Г корпус, 5 давхар

Нийслэлийн Баянзүрх дүүргийн Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 26 өдөр

Дугаар 222/А0260191

Улаанбаатар хот

НТАГ-2026/179/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянзүрх дүүргийн Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Ижил төрлийн бараа, ажил үйлчилгээг худалдан авалт хийхдээ тендер шалгаруулалтын журмыг зөрчин 1,904,373,600.00 (нэг тэрбум есөн зуун дөрвөн сая гурван зуун далан гурван мянга зургаан зуун) төгрөгийн гэрээ байгуулж, шууд худалдан авалт хийсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д "Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална", 10 дугаар зүйлийн 10.3-д "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөөт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.9-д "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол" заалтад заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шууд гэрээ байгуулж, худалдан авалт хийсэн зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 09 дүгээр сарын 30-ны дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэх;

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баянзүрх дүүргийн Засаг даргын тамгын газрын дарга Д.Бат-Өлзий, ерөнхий нягтлан бодогч Б.Алтаншагай нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР

Г.НАНДИНЖАРГАЛ
Я.АЛТАНЦЭЦЭГ
Н.БАТТОГОО

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, А.Амарын гудамж, Соёлын төв өргөө,
Г корпус, 5 давхар

1426090507

Нийслэлийн Баянзүрх дүүргийн Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 223/А0260191

Улаанбаатар хот

НТАГ-2026/179/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянзүрх дүүргийн Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Үйл ажиллагааны чиглэл өөр байгууллагуудаас 101,636,000.00 (нэг зуун нэг сая зургаан зуун гучин зургаан) мянган төгрөгийн засвар, ажил үйлчилгээ зохион байгуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д "улс, орон нутгийн төсөв болон захиалагчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авахад энэ хуулийг дагаж мөрдөнө", 38 дугаар зүйлийн 38.1-д "Ерөнхий гэрээний аргын хоёроугаар үе шатанд захиалагч худалдан авах бараа, үйлчилгээний тоо хэмжээ, хүргэх газар, хуваарь бүхий захиалгын хуудсыг цахим системд илгээж, үнийн санал дуудаж цахим дэлгүүрээс худалдан авна" 10 дугаар зүйлийн 10.3-д "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно" гэж заасантай тус тус нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.9-д "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол" заалтад заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Үйл ажиллагааны чиглэл өөр байгууллагуудаас, худалдан авалт хийсэн зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 09 дүгээр сарын 30-ны дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэх;

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, А.Амарын гудамж, Соёлын төв өргөө,
Г корпус, 5 давхар

1426090511

Нийслэлийн Баянзүрх дүүргийн Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баянзүрх дүүргийн Засаг даргын тамгын газрын дарга Д.Бат-Өлзий, ерөнхий нягтлан бодогч Б.Алтаншагай нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР

The image shows two handwritten signatures in black ink. The top signature is more stylized and appears to be 'Gant'. Below it is another signature, possibly 'Hest', with the date '15/10/24' written next to it. A red rectangular stamp is positioned behind the signatures, but its text is illegible.

Г.НАНДИНЖАРГАЛ
Я.АЛТАНЦЭЦЭГ
Н.БАТТОГОО

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, А.Амарын гудамж, Соёлын төв өргөө,
Г корпус, 5 давхар

Нийслэлийн Баянзүрх дүүргийн Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 224/А0260181

Улаанбаатар хот

НТАГ-2026/179/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянзүрх дүүргийн Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Туршлага судлах, сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулахаар шийдвэр гаргаж ресторан, аяллын компаниудтай гэрээ байгуулан 628,817,000.00 (зургаан зуун хорин найман сая найман зуун арван долоон мянган) төгрөгийн зардал гаргаж, төсвийг үрэлгэн зарцуулсан, ямар хөтөлбөр удирдамжаар хэн явах нь тодорхой бус шийдвэртэй, ажил гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулсан боловч үр дүнг үнэлж, гэрээ дүгнэсэн акт үйлдээгүй зэрэг нотлох баримт хангалтгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.7-д "сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг амралт, сувилал, жуулчны баазад зохион байгуулахгүй байх, шаардлагатай бол хот суурин газарт зориулалтын хурлын танхимд, эсхүл цахимаар зохион байгуулах зэргээр түрээс, шатахуун, албан томилолтын зардлыг хэмнэх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4-д "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" гэсэн заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" заалтад заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1.Төсвийн хэмнэлтийг горимыг хэвшүүлээгүй, гадаад томилолтын зардлыг хязгаарлаагүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 09 дүгээр сарын 30-ны дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэх;

2.Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баянзүрх дүүргийн Засаг даргын тамгын газрын дарга Д.Бат-Өлзий, ерөнхий нягтлан бодогч Б.Алтаншагай нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР

Г.НАНДИНЖАРГАЛ
Я.АЛТАНЦЭЦЭГ
Н.БАТТОГОО

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, А.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар

1426090513

Нийслэлийн Баянзүрх дүүргийн Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 225/А0260171

Улаанбаатар хот

НТАГ-2026/179/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянзүрх дүүргийн Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжүүлээгүй. Хугацаа хэтэрсэн 406,279,800.00 (дөрвөн зуун зургаан сая хоёр зуун далан есөн мянга найман зуун) төгрөгийн авлагын үлдэгдэлтэй, уг авлагуудыг барагдуулах арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3-д "Шалгаагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн хүрээнд хэрэгжүүлсэн ажил, түүний үр дүнг төрийн аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд мэдэгдэнэ", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.5-д "хуваарьт болон хугацаа хэтэрсэн авлага, өр төлбөрийг жилийн төсөвтөө бүрэн тусгаж барагдуулах төлөвлөгөө, хуваарь баталж хэрэгжүүлэх" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.10-д "аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол" заалтад заасныг үндэслэн ШААРДАХ нь:

1.Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжүүлж ажиллаагүй, авлага барагдуулах ажлыг зохион байгуулаагүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 09 дүгээр сарын 30-ны дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэх;

2.Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баянзүрх дүүргийн Засаг даргын тамгын газрын дарга Д.Бат-Өлзий, ерөнхий нягтлан бодогч Б.Алтаншагай нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР

Г.НАНДИНЖАРГАЛ
Я.АЛТАНЦЭЦЭГ
Н.БАТТОГОО

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, А.Амарын гудамж, Соёлын төв өргөө,
Г корпус, 5 давхар

1426090515

Нийслэлийн Баянзүрх дүүргийн Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 09 сарын 25 өдөр

Дугаар 206/А0260191

Улаанбаатар хот

НТАГ-2026/179/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянзүрх дүүргийн Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны цахим хуудсанд таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг долоо хоногийн дотор 46,332,976,900.00 (дөчин зургаан тэрбум гурван зуун гучин хоёр сая есөн зуун далан зургаан мянга есөн зуун) төгрөгийн орлогын 196 гүйлгээ мэдээлэхээс, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 41.339.228,700.00 (дөчин нэгэн тэрбум гурван зуун гучин есөн мянга хоёр зуун хорин найман мянга долоон зуун) төгрөгийн орлогын 149 гүйлгээг хугацаанд нь мэдээлээгүй, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 36, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 155, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 103 шийдвэрийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", 6.4.4-д "таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг" заалтыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" заалтад заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Шилэн дансны цахим хуудсанд тогтоосон хугацаанд мэдээлээгүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 09 дүгээр сарын 30-ны дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэх.

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баянзүрх дүүргийн Засаг даргын тамгын газрын дарга Д.Бат-Өлзий, ерөнхий нягтлан бодогч Б.Алтаншагай нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР

Г.НАНДИНЖАРГАЛ
Я.АЛТАНЦЭЦЭГ
Н.БАТТОГОО

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, А.Амарын гудамж, Соёлын төв өргөө,
Г корпус, 5 давхар

1426090517